



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2026 оны 06 сарын 10 өдөр

Дугаар 250

Улаанбаатар хот

Суралцагчийн тэтгэлэг, сургалтын зээл, төлбөрийн
хөнгөлөлт, буцалтгүй тусламжийн хэрэгжилтийг
хангах зарим арга хэмжээний тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, 8.3 дахь хэсгийг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.2.1.19-д заасан зорилтыг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1.Засгийн газрын “Чөлөөлье” бодлогын хүрээнд дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчдыг “Сургалтын төлбөрийн дарамтаас чөлөөлье” арга хэмжээг хэрэгжүүлж, Засгийн газрын хөтөлбөрөөр дотоод, гадаадын дээд боловсролын сургалтын байгууллагын суралцагчид сургалтын төлбөрийн тэтгэлэг, зээл хөнгөлөлт, буцалтгүй тусламж олгох 2026 оны хяналтын тоог батлагдсан төсөвтөө багтаан шинэчлэн тогтоож, үндсэн шалгуур хангасан суралцагчийг эрэмбэлэх, сонгон шалгаруулалтын зохицуулалт хийх чиглэлээр холбогдох журамд өөрчлөлт оруулах арга хэмжээг авахыг Боловсролын сайд Л.Энх-Амгаланд даалгасугай.

2.Боловсролын зээлийн сангаас 2026 онд олговол зохих сургалтын төлбөрийн тэтгэлэг, зээл, хөнгөлөлт, буцалтгүй тусламжийн санхүүжилтийн дутагдах хэсгийг шийдвэрлэх талаар шаардлагатай арга хэмжээг хууль тогтоомжийн хүрээнд авч ажиллахыг Боловсролын сайд Л.Энх-Амгаланд даалгасугай.

3.Засгийн газраас баталсан холбогдох журамд заасан шаардлага хангасан боловч батлагдсан хяналтын тоонд багтаагүй суралцагчид шаардагдах санхүүжилтийн эх үүсвэрийг Монгол Улсын 2027 оны төсвийн төсөлд тусгах арга хэмжээ авахыг Боловсролын сайд Л.Энх-Амгалан, Сангийн сайд З.Мэндсайхан нарт даалгасугай.



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД

БОЛОВСРОЛЫН САЙД

Н.УЧРАЛ

Л.ЭНХ-АМГАЛАН